

ГАДНЫ ХАЛДЛАГА, ГАЛ УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ ЗӨВЛӨМЖ

Ерөнхий анхаарах зүйлс

1. Музейн аюулгүй байдлын нэгдсэн төлөвлөгөө бий эсэх
2. Цуглуулгын хадгалалт хамгаалалтыг бие хамгаалалт болон электрон арга хэрэгслийн тусламжтайгаар найдвартай хамгаалж байгаа юу?
3. Музейн ажилтнууд ажиллах, музей нээлттэй үед хулгай гэмтлээс хамгаалагдаж чадсан уу?
4. Ойрын үед музей барилга, орчин тойронд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон галын байцаагч, аюулгүй ажиллагааг хангах газрын зөвлөхийн үзлэг хийгдсэн үү?
5. Гал, довтолгоо, үе зэрэг онцгой нөхцөл үүссэн үед танай музейн бүх ажилтнууд ямар арга хэмжээ, ямар дэс дараалалтай хийхээ мэддэг үү? Гамшгийн үед ажиллах багийг томилсон эсэх
6. Аюулын үеийн багаж хэрэгсэл, хамгаалалтын хувцас зэрэг бий эсэх
7. Музейд хохирол учирсан тохиолдолд хохирлын хэмжээг гаргах санхүүгийн баримт үнэлгээ бий эсэх
8. Яаралтай тусламжийн утасны дугаарууд бүрэн эсэх, ажилтнуудын утас зөв эсэх
9. Музейн барилгын, цахилгааны, дулааны зураг бэлэн эсэх
10. Дохиоллын зураг бий эсэх
11. Агааржуулалтын байршлыг зурагт тэмдэглэсэн эсэх
12. Барилгын техникийн үйлчилгээний талаар хөтөлбөр бий юу? Түүнд хангалттай хөрөнгө төсөвлөсөн үү?

Сан хөмрөгийн бүртгэлийн талаар

1. Үзмэр, эд өлгийн зүйлийн бүртгэлийн дэвтэр найдвартай хадгалагдаж буй эсэх
2. Сан хөмрөгт үзмэр, эд өлгийн зүйлээс өөр эд зүйл хадгалагдаж буй эсэх
3. Үзмэр, эд өлгийн зүйлийн байршлын тухай бичиглэл, каталог, акт хаана бий
4. Барилга, үзмэр, эд өлгийн зүйлийг даатгалд хамруулсан эсэх

Гадны халдлага, хулгайн аюулаас сэргийлэх

1. Музейн гадна талыг тойрч, эмзэг газруудыг илрүүлэх, Гадна талд хулгайч нуугдаж музей рүү орохоор газар байна уу? Эрсдэлтэй ямар цэгүүд байна? Хашааны хаалга, авирч болохоор газар, гадна дотор нүх, салхивчийг тагласан эсэх
2. Хэдэн гадна хаалгатай вэ?
3. Музейн дотор хэдэн хаалга байгаа, ялангуяа гадна хаалгаар ороод дотогшоо нэвтэрдэг, коридорын давхар хаалгануудыг үзэж нэн түрүүнд сайжруулах, солих болон яваандаа сайжруулах гэсэн 2 жагсаалт гаргах
4. Хаалганы цоожнуудыг шалгах, дотроосоо онгойдог цоож байвал солих, хаалганд аль талын цоож хэрэгтэйг судлах

5. Хана тааз бат бөх эсэх, гаднаас нэвтрэх нүх сүв бий эсэх, Ж: агааржуулалтын хоолой
6. Гадна цонхны хамгаалалт, сараалж, бэхэлгээ, түгжээг шалгах
7. Цонхны хагархай салхивч бий эсэх
8. Бүх цонхны салхивч түгжигддэг эсэх
9. Ажилтнуудын лацны жагсаалт гаргаж, хянаж байх
10. Бүх түлхүүр 3 хувь эсэх, ямар хүмүүст, ямар хяналттай хадгалагдах талаар журамд тусгагдсан эсэх
11. Өдөр бүр хэрэглэгддэггүй нөөц түлхүүрийг хаана, ямар сейфэнд хадгалах
12. Өдөр бүр хэрэглэгддэг түлхүүрийн бүртгэл, хяналт
13. Сан хөмрөгийн өрөөний хаалга, цоож давхар эсэхийг шалгаж, түлхүүрийн асуудлыг онцгой анхаарах
14. Музейн хосгүй үнэт, үнэтийн сан хөмрөг хир найдвартай хадгалагдаж буй
15. Музейн цахилгаан тасархад нөөц тэжээл автоматаар залгагдах эсэх
16. Ажилтнуудад, ялангуяа харуулуудад гар чийдэн, хонх шүгэл, утас, богино холбоо зэрэг бий эсэх,
17. Музейд хонож ажилладаг ажилтнууд цахилгаан хэрэгсэл залгадаг эсэх,
18. Сан хөмрөгийн өрөөнд цахилгааны залгуур бий эсэх
19. Музейд орж гарч буй бүртгэл, түүний дотор ажилтнууд, эд зүйлийн бүртгэл
20. Үзмэрийн хоргонууд бүрэн бүтэн эсэх, цоож нь ажиллагатаай эсэх
21. Музейд түр орж ирсэн хүнд таних тэмдэг тэмдэг өгдөг эсэх
22. Музейн гадна гэрэлтүүлэг, камер ажиллагаатай, хяналттай эсэх

Галын аюулаас урьдчилан сэргийлэх:

1. Цахилгааны тоног төхөөрөмж хэрэгслийн үзлэг, үйлчилгээг графикаар хийж, захиргаанд тайлагнаж байх, Ж: щит, узель
2. Галын хор хаана хэдэн ширхэг байгаа, хэн хариуцах
3. Усны хоолой, хошуу ажиллагаатай эсэх цоож, лацтай эсэх
4. Галын хор хэрэглэх заавартай эсэх, ажилтнуудыг сургалтад хамруулсан эсэх
5. Галын гарц зэргийн тэмдэглэгээ тавигдсан эсэх
6. Галын гарц хаалга онгойдог эсэх, түлхүүр нь бэлэн эсэх,
7. Аюулын гарцууд чөлөөтэй эсэх, эд хогшил зэргийг наана нь овоолсон эсэх
8. Музейд хаана хаана цахилгаан хэрэгсэл залгадаг
9. Тоос сорогч, индүү зэрэг бий эсэх,
10. Галын дуудлага хаанаас өгөх, дуудлагын утас хаана байрлуулах
11. Цахилгааны болон холбооны утас хамгаалагдсан, шалбарсан эсэх
12. Галын байцаагчтай тогтмол харилцдаг уу
13. Шатах дэлбэрэх зүйл энд тэнд буй эсэх, одоо хаана юу ямар хэмжээтэй хадгалагдаж буй

Дохиолол

1. Дохиоллын үзэлг үйлчилгээ хийгддэг эсэх
2. Дохиоллын утас унжсан, хамгаалалтгүй зэрэг дутагдал бий эсэх
3. Дохиоллын мэдрэгчүүдэд гэмтэл учруулах ямар эрсдэл бий эсэх. Ж: 1,5 метрээс дотогш эд зүйл тавьсан эсэх

4. Гэрэл солих, парнаас хий авах зэрэг үйлчилгээ хийхэд дохиоллын утас гэмтэхээр байрлалтай эсэх
5. Хяналтын дэлгэц, камер ажиллагаатай эсэх, бичлэгийн хяналт, хадгалалт, устгалын зэрэг журам бий эсэх
6. Дохиолол залгахын өмнө хийгдэх шалгалт, музейд гадны хүн үлдсэн эсэх,
7. Дохиолол, аюулгүй байдал хариуцсан ажилтнууд эзгүй тохиолдлыг урьдчилан зохицуулсан эсэх
8. Музейн энд тэнд замбараагүй тавьсан эд зүйл бий эсэх
9. Дохиоллын төвлөрсөн удирдлагад музей хяналт тавьж чадах эсэх

Усны аюул

1. Сантехникийн засвар хийгдсэн эсэх, шугам, бойлуур сольсон, винт зэргийг сольсон тухай судалгаа бий эсэх

Д.Бумаа Ph.D

МҮМ-н Музей судлал мэргэжил арга зүйн төвийн дарга
Музейн мэдээлэл. МҮМ-н мэргэжил-арга зүй, мэдээлллийн сэтгүүл.
2009.IY сар. № 01. Тал. 17.